Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 18,695,261.9 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь дээд шатны төсвөөс хуваарилсан санхүүжилтийг 1,904,410.1 мянган төгрөгөөр илүү, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 25,743.9 мянган төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 3,672.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	**71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ**				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	14,492,676.2	14,518,419.9	(25,743.7)	100,2%
1.2	80219-Харуул хамгаалалт	144,000.0	140,327.9	(3,672.1)	97.4%
1.3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	42,875.0	42,875.0	-	100.0%
1.4	81639-Тер төлбөрийг нь хариуцах эмийн зардал	882,635.0	882,635.0	-	100.0%
1.5	83603- Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	4,573,192.5	2,668,782.4	1,904,410.1	58.4%
1.6	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	442,221.7	442,221.7	-	100.0%
	НИЙТ ДҮН	**20,577,600.4**	**18,695,261.9**	**1,882,338.5**	**90,9%**

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд байгууллага нэмэлт санхүүжилтийн данс ашиглаагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.

Тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс нийт 2,702,001.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс: нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2,545,755.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур болон харуул хамгаалалтын үйлчилгээ авсан байна. Харьцуулалтын аргаар 156,246.8 мянган төгрөгийн шатахуун, цэвэрлэгээний материал, бичиг хэргийн материал худалдан авч, шууд худалдан авалтын аргаар 104,492.3 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, аж ахйн материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах элэгдлээ нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах талаар саналыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, орлогыг бүрэн бүрдүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Оюунтуул, аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер , гүйцэтгэх захирал Н.Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер Я.Алтанцэцэг, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 22,467,926.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 224,679.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор байгууллага чиг үүргийн давхардал бүхий албан томилгоо хийгээгүй, төсвийн хөрөнгөөр архи, согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах эм, эмнэлгийн хэрэгсэл, үйл ажиллагааны бусад шаардлага бүхий материалыг "ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулалтыг гүйцэтгэж худалдан авалт хийсэн байна.

Нэгдсэн судалгааны талаар:

- Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрмийн 2.3.1, удидлагын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдөр 17-ны өдрийн шийдвэр, ЭМТ-ийн даргын 2022 оны Б/230 тоот тушаалаар унааны хөнгөлөлтийг 8.0

мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр тогтоон олгож байсныг ЭМТ-ийн даргын 2025 оны Б/274 тоот тушаалаар унааны хөнгөлөлтийг 13.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоожээ.

- НЭМГ-ын даргын 2024 оны А/132 дугаар тушаалаар бүтэц, орон тоо 399, Гүйцэтгэлээр 380 орон тоогоор ажиллаж, ЭМСайдын 2025 оны А/3266 тоот чиглэлийн дагуу захиргааны 6 ажилтанг цомхотгосон байна.
- Биет бус хөрөнгийн данс бүртгэлд нийт 4 төрлийн 5,464.5 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байна.
- НӨХГ-ын сонгон шалгаруулалтын зар байршуулах үйл ажиллагаатай холбоотойгоор эмийн сангийн түрээсийн зарыг өдөр тутмын сонинд байршуулж, 1,350.0 мянган төгрөгийн зарцуулан мэргэжлийн үйлчилгээний төлбөр зардлаар тайлагнасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2,001,512.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий зарлагын 1,652,744.6 мянган төгрөгийн 96 гүйлгээ, орлогын 348,768.3 мянган төгрөгийн 32 гүйлгээг мэдээлээгүй, 3 мэдээллийг хугацааг хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг 37.1.13.албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; " гэж заасантай нийцээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 9,042,956.0 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илрүүлж, 9,042,956.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлж 11 алдаа, зөрчлийг арилгаж, шийдвэрийг хэрэгжүүлсэн тул 9,042,956.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулгаар бүртгэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 437,698.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	437,698.0	2	437,698.0	100.0
Зөвлөмж	1	0	1	0	100.0
Нийт дүн		**437,698.0**		**437,698.0**	**100.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар:

1. НЭМГазар, Дүүргийн ЗДТГазраас шилжүүлсэн орлогыг төрийн сангийн гүйлгээний эрх нээх журамтай уялдуулан туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэхийг ЭМЯ-ны 2021 оны 4/422 тоот албан бичгээр чиглэл өгсөн нь Санхүүгийн тайлан бэлтгэх заавар журамтай нийцэхгүй байгааг цаашид анхаарч, дүрэм журамд нийцүүлэх;
2. Харилцагч байгууллагуудтай эмийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч И-баримтын системд байгаа нэхэмжлэхийн дүн санхүүгийн байдлын тайлан дахь өглөгийн дүнтэй таарахгүй байгааг анхаарах;
3. Тайлант онд тус эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын нөөцөд 4,830 хүн тун, 41 ӨЭМТ-ийн дархлаажуулалтын цэгүүдэд 6,770 хүн тун, нийт 373,454.4 мянган төгрөгийн үнэ бүхий вакциныг гэрээний дагуу тусгай зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК-д устгуулахаар шилжүүлсэн байна. Энэ нь ХӨСҮТ-өөс хувиарлагдан ирж буй вакцины хадгалах хугацаа богино, мөн дархлаажуулалтын хамралт буурсантай холбоотойгоор вакцины үлдэгдэл үүсэж, хугацаа дуусах эрсдэл бий болсонтой холбоотой байна. Иймд дээд

шатны байгууллагаас вакцины хэрэгцээний тооцоо, судалгааг бодитой үндэслэлд тулгуурлан гаргаж, вакцинжуулалтын нийлүүлэлт, зарцуулалт, хадгалалт, устгалын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, хяналтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ТЕЗ-д зөвлөж байна.;

4. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батласан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг сайжруулахтай холбоотойгоор Сангийн яамны Finperform.mof.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах, дансны жишиг жагсаалтыг тус сайт дахь бүртгэлтэй тохируулах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,043,962.6 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- ЭМЯ-наас ирүүлсэн шийдвэрийн дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах эмийн захиалга хийж 3,860.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардал дансанд буруу бүртгэсэн;
- ЭМЯ-наас үнэ төлбөргүй олгосон 28,160.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлант онд хүлээн авч орлогоор бүртгээгүй;
- Санхүүгийн байдлын тайланд 1,761,941.7 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг болон ХХОАТ-ын өглөгийг цалингийн өглөгөөр буруу тусгасан;
- Туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн 250,000.0 мянган төгрөгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн нь УСНББОУС-1, "Ангилал", "иж бүрэн байх", "үнэлгээ ба хувиарлалт" батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 29,614.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 823.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлж, 6,310.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 29,614.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Хавсран болон түр орлон гүйцэтгэсэн ажилтны цалингийн нэмэгдлийг тухайн албан тушаалын цалингаас тооцоогүй үндсэн цалингаас бодож 823.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батласан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох" журмын 2.4. Төрийн албаны тухай хуулийн "*3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хугацаагаар тооцож олгоно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 823.7 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. НДШ, ХХОАТ-ын өр төлбөр оны эхний үлдэгдлээс 79.0 хувиар өсөж гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийг зөв удирдаагүй, ажилтнуудыг НД-ын сангаас авах тусламж үйлчилгээг эдлэх нөхцлөөр хангаж ажиллаагүй байна. ХХОАТ, НДШ-ийн өр төлбөрийг *(997,404.8 мянган төгрөгийг)* төсөвт төлж барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн *"5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*; ХХОАТ-ын тухай хуулийн "*25 дугаар зүйл.Албан татвар суутган тооцох, төсөвт төлөх, 27 дугаар зүйл.Албан татварын тайлан хүргүүлэх хугацаа, 27.1.Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ." Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйл Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, 21.1."Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НДШ, ХХОАТ-ын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллага нь 22,480.3 мянган төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*", 10.5-д "*Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно*", 31 дүгээр зүйлийн 31.1-т "*Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна*" гэж заасантай нийцэхгүй, ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Элэгдлээрээ өртгөө нөхсөн (*1,437,316.5 мянган төгрөгийн)* анхны өртөгтэй 106 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын *"Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" журмын 7.1 "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"* гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө

нөхсөн 106 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах талаар саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2. Орлогын данстай холбоотой

Илрүүлэлт-1: ЭМД-ын сангаас 2025 онд нийт 14,222.4 мянган төгрөгийн ЭМДС-н санхүүжилтийн орлого нэхэмжилснээс 6,310.8 мянган төгрөгийн орлогыг ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 тоот тогтоолоор баталсан "ЭМДС-аас зардлын төлбөрийг хариуцах тусламж үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, санхүүжүүлэх журам"-ын 3.3.1 "ЭМДС-аас чанартай тусламж, үйлчилгээ худалдан авах зарчмыг баримтлах бөгөөд ЭМДЕГ-ын чанар болон төлбөрийн хяналтын үйл ажиллагааны хүрээнд зөрчил илэрсэн нэгж тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхгүй." гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмчийн хасагдуулгаар хасагдсан орлогыг өмнөх оны дүнгийн 20-иос доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллан цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМЯ-наас ирүүлсэн шийдвэрийн дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах эмийн захиалга хийж төлбөрийг шилжүүлсэн боловч санхүүгийн байдлын тайланд УГЗардал дансанд буруу бүртгэсэн байна.	1	3,860.0			1	3,860.0	1	3,860.0				
ЭМЯ-наас хувиарласан үндсэн хөрөнгийг тайлант онд хүлээн авч орлогоор бүртгээгүй байна.	1	28,160.9			1	28,160.9	1	28,160.9				
Санхүүгийн тайлангийн хоорондын уялдаа, санхүүгийн тайланг шалгахад НДШ-ийн өглөг болон ХХОАТ-ын өглөгийг цалингийн өглөгөөр буруу тусгасан.	1	1,761,941.6			1	1,761,941.6	1	1,761,941.6				
Идэр чийрэг-монгол цэрэг дэд төслийн орлогыг тайлант оны туслах үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрсөн байна. Уг урьдчилан сэргийлэх	1	250,000.0			1	250,000.0	1	250,000.0				

үзлэг, эмчилгээг БЗД ЭМТөв нь тайлант онд хийж хэрэгжүүлээгүй тул урьдчилж орсон орлогоор бүртгэх												
Дүн	4	2,043,962.6			4	2,043,962.6	4	2,043,962.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хавсран болон түр орлон гүйцэтгэсэн ажилтнуудаас 2 ажилтны цалинг хавсран ажилласан албан тушаалын цалингаас бодоогүй илүү цалин олгосон байна.	1	823.7	1	823.7								
НДШ, ХХОАТ-ын өглөг оны эхний үлдэгдлийг төсөвт төлж барагдуулаагүй байна.	1	-			1	-						
ЭМДС-н санхүүжилтын орлого нэхэмжилсэн орлогын кодчилол буруу, эмнэлгийн зарим үйлчилгээний анхан шатны баримт дутуу нотолгоотой зэргээс шалтгаалан орлогыг дутуу бүрдүүлсэн байна.	1	6,310.9					1	6,310.9				
Элэгдлээ нөхсөн 106 үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгуулаагүй байна.	1	-				-	1	-				
Тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулах ёстой бараа материалын худалдан авалтыг шууд гэрээ хийн худалдан авсан байна.	1	22,480.0			1	22,480.0						
Дүн	5	29,614.90	1	823.7	1	22,480.0	2	6,310.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 1,652,744.6 мянган төгрөгийн 96 гүйлгээ, орлогын 348,768.3 мянган төгрөгийн 32 гүйлгээг мэдээлээгүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	2,001,512.8							1	1		
Дүн	1	2,001,512.8							1	1		

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2026 оны 02 дугаар сарын 25 № 58/250 25 НАГ Улаанбаатар хот

НТАГ-2026/170/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хавсран болон түр орлон гүйцэтгэсэн ажилтны цалингийн нэмэгдлийг тухайн албан тушаалын цалингаас тооцоогүй үндсэн цалингаас бодож 823,680.00 (найман зуун хорин гурван мянга зургаан зуун ная) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний 9 дүгээр тогтоолоор батласан журмын 2.4-д "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох",Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-д *"тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно."* гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Илүү тооцож олгосон 823,680.00 (найман зуун хорин гурван мянга зургаан зуун ная) төгрөгийг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (И.Батзаяа), Ерөнхий нягтлан бодогч (Р.Цэнд-Аюуш) нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх аудитын газарт[1] ирүүлэхийг ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (И.Батзаяа), Ерөнхий нягтлан бодогч (Р.Цэнд-Аюуш) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110033

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 155/250225 ННЗ Улаанбаатар хот

НТНГ- 2026/170/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус байгууллага нь 22,480.300 (Хорин хоёр сая дөрвөн зуун наян мянга гурван зуу) төгрөгийн бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*", 10.5-д "*Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно*", 31 дүгээр зүйлийн 31.1-д "*Захиалагч өрөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна*" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсэхгүй бол*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (И.Батзаяа), ерөнхий нягтлан бодогч (Р.Цэнд-Аюуш) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар
1426090249

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 156/25025 ННЗ Улаанбаатар хот

НТАГ-2026/170/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төвсийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

НДШ, ХХОАТ-ын өр төлбөр оны эхний үлдэгдлээс 79.0 хувиар өссөн нь гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийг зөв удирдаагүй, ажилтнуудыг НД-ын сангаас авах тусламж үйлчилгээг эдлэх нөхцлөөр хангаж ажиллаагүй байна. ХХОАТ, НДШ-ийн өр төлбөр *(997,404.8 мянган)* төгрөгийг төсөвт төлж барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн *"5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*; ХХОАТ-н тухай хуулийн *27 дугаар зүйлийн 27.1-д "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ."* Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн *21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг хуульд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (И.Батзаяа), ерөнхий нягтлан бодогч (Р.Цэнд-Аюуш) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090247

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 05 өдөр Дугаар 154/250.254НЗ Улаанбаатар хот

НТАГ-2026/170/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий зарлагын 1,652,744,600.00 (Нэг тэрбум зургаан зуун тавин хоёр сая долоон зуун дөчин дөрвөн мянган зургаан зуу) төгрөгийн 96 гүйлгээ, орлогын 348,768,300.00 (Гурван зуун дөчин найман сая долоон зуун жаран найман мянга гурван зуу) төгрөгийн 32 гүйлгээг мэдээллээгүй, 3 мэдээллийг хугацааг хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль *тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", 42 дугаар зүйлийн *42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"*, 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2.Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй Цалин хөлсний Нягтлан бодогч Ц.Ариунаа-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090251

2026 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (И.Батзаяа)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР	Я.АЛТАНЦЭЦЭГ
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ	Н.ЭНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар